



УЛААНБААТАР  
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

**ТОГТООЛ**

1981 оны 10 дугаар  
сарын 1 ны өдөр

Дугаар 229

Улаанбаатар  
хот

**ЭМНЭЛЭГ, ЯСЛИЙН ТӨВЛӨРСӨН НЯГТ-  
ЛАН БОДОХ АНГИ БАЙГУУЛАХ ТУХАЙ**

Хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

1. Найрамдлын районы харьяа эмнэлэг, яслиудын нягтлан бодогч нарыг нэгтгэн төвлөрсөн нягтлан бодох анги зохион байгуулж, 1982 оны I-р сарын I-нээс эхлэн ажиллуулахыг хотын санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/, хотын эрүүлийг хамгаалах газар /н.Бямбаа/-т даалгасугай.

2. Төвлөрсөн ня-бо ангийн ажиллах журам, ня-бо нарын ажил үүргийн хуваарийг хянаж батлан мөрдүүлж, конторын байр болон байнгын удирдлагаар хангаж ажиллуулахыг хотын санхүүгийн хэлтэс, хотын эрүүлийг хамгаалах газар, Найрамдлын районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.Тогоо/-д даалгасугай.

3. Төвлөрсөн ня-бо ангийн орон тооны асуудлыг БНМАУ-ын Хөдөлмөр, нийгэм хангамжийн улсын хороонд оруулж шийдвэрлүүлэхийг санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ  
ДАРГА Л.ДУГАРЖАВ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Ч.ЖАМБАЛ